



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/516

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Алтаргана 2024” наадмын бэлгэдэл хөх бухын 3м өндөртэй 1 ширхэг сувенир бүтээх ажлыг 3,000,000 (гурван сая) төгрөгөөр дизайн технологийн багш Д.Золбаяртай гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн хүлээлгэн дизайн технологийн багш (Д.Золбаяр)-д даалгасугай.

3. Дээрх хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6324010682

07 дүгээр сарын 19-ны өдрийн А/5/Б дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт

“Алтаргана 2024” олон улсын XV их наадамд сувенир бүтээх ажлын зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
2	Хөөсөнцөр	3м	460,000	1,380,000
3	Замаск	25 кг	45,000	45,000
4	Кноп	25 кг	45,000	45,000
5	Тор	10 боодол	12,000	120,000
6	Шбатал	2ш	2,500	5,000
7	Зүлгүүр	10м	2,500	25,000
8	Акрил будаг	10 будаг	16,000	160,000
9	Цавуу 505	5 уут	8,500	42,500
10	Багс	3 ширхэг	2,500	2,500
11	Ажлын хөлс	1	1	1,175,000
Нийт үнэ				3,000,000